

Эрдэнэ Ресурс нь Баян Хөндийн нөөцийн техникийн 43-101 тайланг бүртгүүлж, хайгуулын үр дүнг танилцууллаа

Канад улс, Нова Скошиа муж, Халифакс хот – 2018 оны 11 сарын 5

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE:ERDN) (цаашид “Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани” гэх) нь өөрийн 100% эзэмшлийн Хөндий алтны төслийн нөөцөд багтсан Баян Хөндий ордын NI 43-101 стандартын эрдсийн нөөцийн тайланг олон нийтэд тайлагнан, SEDAR-т бүртгүүлснийг мэдээлэхэд таатай байна. Түүнээс гадна Компани нь баруун өмнөд Монголын тусгай зөвшөөрлийн талбай дахь техникийн болон хайгуулын судалгааны үр дүнг үүгээр мэдээлж байна.

Компанийн ерөнхийлөгч, гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ “Баян Хөндий болон Алтан Нар ордуудыг багтаасан Хөндий Алтны Төсөл нь хөрөнгө оруулалтын ховорхон боломжуудын нэг юм. Орд нь өндөр агуулгатай, газрын гадаргад ойр, металлургийн таатай нөхцөлтэйгөөрөө онцлог” гэв “Мөн Хөндий Алтны Төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг энэ оны 4-р улиралд багтаан боловсруулж, хөрөнгө оруулагчдадаа танилцуулахаар төлөвлөж байна” хэмээн төслийн дараагийн үе шатыг тодорхойлов.

Петер Акерли: “Хөндий алтны төслийг ашиглалтын түвшинд хөгжүүлэхээс гадна шинээр илрүүлсэн алтны дүүрэгт шинэ ордууд илрүүлэх, одоогийн нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хайгуулын хөтөлбөрийг үргэлжлүүлнэ. Алтан Сум, Хойд Хөндийн хайгуулын хөтөлбөрөөс гадна манай техникийн баг Монгол улсын баруун өмнөд бүсийн боломжит хайгуулын талбайнуудад тусгай зөвшөөрөл сонгон шалгаруулалтын журмаар авах боломжуудыг судалж байна.”

Техникийн тайлангийн бүртгэл

- Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт орших өөрийн 100% эзэмшлийн Баян Хөндий алтны ордын нөөцийн тайланг NI 43-101 (“National Instrument 43-101”) тайлагналын стандартын дагуу бүртгүүллээ. Техникийн тайланг RPMGlobal Asia Limited боловсруулсан бөгөөд SEDAR (www.sedar.com) дахь Компанийн хуудсанд “Bayan Khundii Gold Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia, National Instrument 43-101 Mineral Resource Technical Report” нэртэйгээр 2018 оны 11 сарын 1-нд байршуулав.
- Алтан Нар ордын нөөцийн тайлан нь Хөндий Алтны Төслийн дагалдах тайлан бөгөөд SEDAR (www.sedar.com) -д “Altan Nar Gold Project, Bayankhongor Aimag, Southwest Mongolia, National Instrument 43-101 Mineral Resource Technical Report” нэртэйгээр 2018 оны 6 сарын 21-нд байршуулсан.

- Хөндий Алтны Төслийн нөөцийн тайланд:
 - 0.6-0.7 г/т захын агуулгаар тооцвол¹: 2.3 г/т алтны дундаж агуулга бүхий 751,000 унц алтны бодит нөөц, 1.8 г/т алтны дундаж агуулга бүхий 291,000 унц алтны боломжит нөөц тогтоогдсон.
 - 1.4 г/т захын агуулгаар тооцоход 3.7 г/т алтны дундаж агуулга бүхий 642,000 унц алтны бодит нөөц, үүнд 5.2 г/т алтны дундаж агуулга бүхий 357,000 унц бодит нөөц багтаж байна.
 - 0.6-0.7 г/т захын агуулгаар Алтны дүйцэх нэгжээр (“Алтны эквивалент” буюу “AuEq”): 2.7 г/т AuEq агуулга бүхий 886,000 унц бодит нөөц, 2.3 г/т AuEq агуулга бүхий 382,000 унц боломжит нөөц агуулагдаж байна.

Техникийн судалгаа

- 2018 оны 9 сард танилцуулсан Хөндий Алтны Төслийн нөөцийн тайлангийн хэвлэлийн мэдээний дараа Эрдэнэ Ресурс нь төслийн анхан шатны эдийн засгийн тооцооллыг хийж эхлүүлсэн бөгөөд 2018 оны 4-р улиралд эцэслэхээр төлөвлөж байна.
- Мөн Эрдэнэ Ресурс нь Баян Хөндий болон Алтан Нарын ашиглалтын тусгай зөвшөөрлийн өргөдөлтэй холбоотой техникийн судалгаануудыг 2018 оны 4-р улиралд хийхээр төлөвлөсөн.

Бүс нутгийн хайгуулын хөтөлбөр

- Компани нь 11.4 км урттай Баян Хөндий тусгай зөвшөөрлийн талбайд орших Хойд Хөндий болон Алтан Сум хайгуулын бүсүүдэд 2018 оны 3-р улиралд 3,452 метрийн 25 алмазан өрөмдлөг хийлээ. Үүнд:
 - Алтан Сумд хийсэн өрмийн судалгаагаар нийт өрмийн 70% нь алтны эрдэсжилт бүхий гажилтыг огтолсон (>0.1 г/т алтны агуулгатай), үүнээс гуравт нь 20 г/т алтны агуулга бүхий 1-2 метрийн интервал илэрсэн.
 - Алтан Сум дахь алтны эрдэсжилт бүхий талбайг тэлэх зорилгоор хийсэн өрмийн цэг (ADD-18) нь биетийн суналыг баруун зүгт 500 метрээр тэллээ. Өнөөгийн байдлаар нийт 1.2 км (сунал дагуу нээлтэй) урттай талбайд алтны аномаль бүхий коридорыг үүсгэж буйг илрүүлсэн бөгөөд хүдрийн биет байх магадлалтай хэсгээс өмнө зүгт 400 метрт мөн алтны эрдэсжилт илрүүлээд байна.
 - Алтан Сумын өмнөд хэсэгт структурыг ташуу өрөмдсөн өрмийн судалгаагаар гүндээ (бодит гүн 100 метрт) алтны эрдэсжсэн аномалийг огтолсон.
 - Энэхүү эрдэсжсэн трендэд хийх цаашдын өрөмдлөгийн хөтөлбөрийг эхлүүлэхээс өмнө структурын огтлол, тэлэлтийг тодорхойлж, эрдэсжсэн бүсийн ойлголтыг нэмэгдүүлэн, цаашид боломжит талбайг илрүүлэх зорилгоор өндөр нягтаршил бүхий соронзон судалгааг эхлүүлсэн.
 - Хойд Хөндийн өмнөд хэсэгт дөт гүнд хийсэн 3 өрмийн судалгаагаар газрын гадаргаас эхлэн 66 метрийн босоо гүнд 2.1 г/т хүртэлх алтны хүдэржилттэй холбоотой олон үе шаттай эпитеpmаль кварцын штокверк болон брекчийн хувирсан монзонитод огтолсон.

¹ RPMGlobal нь илээр ашиглах нөөцийн захын агуулгыг Баян Хөндийн тайланд 0.6 г/т, Алтан Нарын тайланд 0.7 г/т, ил уурхайгаас доош орших нөөцийн захын агуулгыг 1.4 г/т-оор тооцоолохыг зөвлөсөн.

- Компанийн 51%-ийн эзэмшлийн Улаан лицензийн талбайд 2018 оны 3-р улиралд анхан шатны хайгуулын өрөмдлөг хийсэн бөгөөд тусгай зөвшөөрлийн төв хэсэгт 1.3 км талбайд 1,050 метрийн 3 өрөмдлөг хийсэн. Гурван цооног гурвуулаа галт уулын чулуулагт байх хэсэгчлэн орших, зэсийн ахиу агуулгатай кварц-пиритийн зэрэгцээгээс штокверк судлуудыг огтолсон ба мөн газрын гадарга дээрх пропицитийн хувирлаас газрын гүн дэх филлик (кварц-серицит-пирит) хувирлын тодорхой ялгагдах бүсчлэлийг огтолсон.
- 2018 оны 3-р улиралд Монгол улсын Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яам хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгож эхэлсэн:
 - Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт хамгийн том хувийн геологийн мэдээллийн санг бүрдүүлж, 22 хэтийн төлөвтэй талбайг тодорхойлсон бөгөөд энэхүү судалгаанд тулгуурлан сонгон шалгаруулалтад оролцохоор төлөвлөж байна.
 - Эрдэнэ-Текийн гэрээний дагуу Тек Ресурс Лимитед нь сонгон шалгаруулалтаар эзэмших боломжтой хайгуулын тусгай зөвшөөрлийн тодорхой талбайд хамтран ажиллах опцион эзэмшдэг.

Хөндий алтны төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн терреинд байрладаг. Энэхүү Төв Азийн Орогены бүс нь БНХАУ-ын нутагт хил дагуу болон бүсийн баруун чиглэлд эпиптермаль алт болон порфирийн зэс-алтны ордууд сайн судлагдсан байдаг боловч Монгол улсын хувьд 1990-ээд оны дунд үеэс ардчилсан нийгэмд шилжин, гадаадын хөрөнгө оруулалттай компаниудад хайгуул хийх боломжийг олгосноор судлагдаж эхэлсэн. Ийнхүү судлагдсанаар дэлхийн хэмжээний алт-зэсийн орд болох Оюу Толгойг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс нь Монгол улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлээд байна. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардаг хоорондоо 16 км зайд орших Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Мөн Хөндий алтны төслөөс зүүн зүгт 40 км зайд Компани өөрийн 100% эзэмшил бүхий Зуун Мод зэс-молибденийн ордыг нээн илрүүлсэн.

Өнгөрсөн 2 жилийн хугацаанд Баян Хөндий төслийн талбайд өрөмдлөгийн судалгаагаар 158 г/т алтны агуулга бүхий 14 метрийн зузаан интервал, үүнээс 1 метр зузаан интервалд 2,200 г/т алтны өндөр агуулга илрүүлсэн. Алтан Нард 10.3 г/т алтны агуулга бүхий 20 метрийн зузаан интервал, түүнд 1 метрийн турш 101 г/т өндөр алтны агуулгыг илрүүлсэн. Энэхүү хоёр ордоос гадна Компани нь бүс нутгийн хайгуулын хөтөлбөрийг үргэлжлүүлэн, 2018 оны 4-р улиралд анхан шатны эдийн засгийн тооцооллыг боловсруулахаар төлөвлөж байна. Хэдийгээр хайгуулын анхан шатанд явж буй боловч энэхүү дүүрэг суурь болон үнэт металлын систем, зэс-алтны порфирууд, дундаж сульфиджилттэй/ карбонат суурь металлын алтны ордууд болон бага сульфиджилттэй эпиптермаль алт болон алт-мөнгөний системүүдийг багтааж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Майкл МакДоналд (Michael A. MacDonald) нь Компанийн Хайгуул эрхэлсэн дэд ерөнхийлөгч, мэргэшсэн геосудлаач (P.Geo.) (Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба энэ мэдээлэлд багтсан техникийн мэдээллийг хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс (“SGS”) лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдэцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт (“QA/QC”)-ын протоколыг гүйцэтгэсэн.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад улсад бүртгэлтэй хайгуулын компани юм. Компани нь Монгол улсын баруун урд бүсэд хайгуул хийх эрх бүхий 4 хайгуулын, 1 ашиглалтын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг Компанийн вебсайт www.erdene.com -оос авч танилцах боломжтой. Компанийн тухай тодорхой мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрэх магадлалтай тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш болно. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон Гүйцэтгэх захирал

Кэн В. МакДоналд, Дэд ерөнхийлөгч болон Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419

Емайл: info@erdene.com

Вебсайт: www.erdene.com

Твиттер: @ErdeneRes